



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР НИЙЦЛИЙН АУДИТЫН АЛБА



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ”-Д
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: УАГ-НАГ-2020/01/-НА

Чойбалсан хот 2020 он



Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер В.Цэнгэлмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Батжаргал
Утас: 7058-4207, Цахим хаяг: batjargalb@audit.gov.mn
Аудитор М.Ухаанбилэг
Утас: 7058-4207, Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn



Товчилсон үгийн тайлбар.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	4

БҮЛЭГ 1. АЙМГИЙН ТЕЗ-ИЙН ТӨСӨВТ ХАМААРАХ БАЙГУУЛЛАГУУД НЬ ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН МЭДЭЭЛЛҮҮДИЙГ ХУГАЦААНД НЬ БҮРЭН БАЙРШУУЛАХГҮЙ БАЙНА.....

1.1 Аймгийн төсвийн байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4-т заасан мэдээллийг 71,7 хувьтай мэдээлсэн байна.....	5
1.2 Мэдээллийн самбар дахь шилэн дансны мэдээллийг тухай бүр шинэчлээгүй байна.....	8

БҮЛЭГ 2. ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 3 ДУГААР ЗҮЙЛИЙН 3.1.3, 3.1.4, 3.1.5-Д ЗААСАН БАЙГУУЛЛАГУУД ХУУЛЬД ЗААСАН МЭДЭЭЛЛҮҮДИЙГ БҮРЭН МЭДЭЭЛСЭН БАЙНА.....

2.1 ДБЭХС ТӨХК нь Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.....	9
2.2 Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр, хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын мэдээлэл аймгийн ЗДТГ шилэн дансны цахим хуудсанд бүрэн мэдээлэгдсэн байна.....	10
2.3 Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллагууд шилэн дансны цахим хуудсанд зарлага, санхүүжилтийн мэдээллээ байршуулсан байна.....	10

БҮЛЭГ 3: ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ХАМРАХ ХҮРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫГ ХЯНАЛТ ШАЛГАЛТАД БҮРЭН ХАМРУУЛСАН Ч ХЭРЭГЖИЛТИЙГ БОДИТОЙ ҮНЭЛЭЭГҮЙ БАЙНА.....

3.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудыг хяналт шалгалтад бүрэн хамруулж, бодитой үнэлж, дүгнээгүй байна.....	11
3.4 Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.....	11

ДҮГНЭЛТ:.....12

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН

САНАЛ:.....13

ЗӨВЛӨМЖ:.....14

ТУШААЛ:.....15



Товчилсон үгийн тайлбар

НА	Нийцлийн аудит
НАГ	Нийцлийн аудитын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ДБЭХС	Дорнод бүсийн эрчим хүчний систем



**Аудит хийх
үндэслэл, бүрэн
эрх**

Аудитын зорилт

**Аудитын хамарсан
хүрээ**

**Аудитын арга зүй,
шалгуур үзүүлэлт**

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх
мэдэгдэл**

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны 05 дугаар тогтоол, “Аудитын төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны А/100 дугаар тушаалаар батлагдсан сэдвийн дагуу, Төрийн аудитын тухай хуулийн 15.2-д заасан Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэсэн. Үүнд:

- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх.
- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлсэн эсэх
- Хуулийн 8 дугаар зүйлд заасан холбогдох байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлсэн эсэх

Аудитад Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 дахь хэсэгт хамаарах 200 хуулийн этгээд, 3.1.3 дахь хэсэгт хамаарах 1 ТӨХК, 3.1.4 дэх хэсэгт улсын төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр төсөл, хөтөлбөр гүйцэтгэгчид, 3.1.5 дахь хэсэгт хамаарах 14 хуулийн этгээд хамрагдсан.

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 4000, Нийцлийн аудитын түр журамд заасны дагуу холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, байгууллагаас шалгах хуудсаар авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, тулган баталгаажуулах, анхны баримтаас хөөн шалгах, бодит байдал дээр оршин байгааг үзэх зэрэг аудитын горимуудыг ашиглав.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер В.Цэнгэлмаа хэрэгжүүлж, нийцлийн аудитын албаны ахлах аудитор Б.Батжаргал, аудитор М.Ухаанбилэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын талбарын ажлыг 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрөөс эхлүүлж, тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн УАГ-ын Нийцлийн аудитын газар болон аймгийн Засаг даргад 2020 оны 05 дугаар сарын 01-ний өдөр хүргүүлээ.



1. АЙМГИЙН ТЕЗ-ИЙН ТӨСӨВТ ХАМААРАХ БАЙГУУЛЛАГУУД НЬ ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН МЭДЭЭЛЛҮҮДИЙГ ХУГАЦААНД НЬ БҮРЭН БАЙРШУУЛАХГҮЙ БАЙНА.

1.1 Аймгийн төсвийн байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4-т заасан мэдээллийг 71,7 хувьтай мэдээлсэн байна.

Орон нутгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан ангилалд хамаарах 114 төсөвт байгууллага, 28 орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, аймаг сумдын 15 төрийн сан, нийт 157 байгууллага нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдсан байна. Эдгээр байгууллагууд нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллүүдийг цахим хуудсанд бүрэн байршуулсан эсэхийг анхан шатны баримт материалтай нь тулган шалгалаа.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтын хэрэгжилт 89.0 хувьтай байна.

Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1

Шилэн дансны тухай хуулийн холбогдох зүйл заалт	Хамрагдсан байгууллага	Мэдээлбэл зохих мэдээлэл	Мэдээлсэн хувь	Дундаж хувь
6 дугаар зүйлийн 6.1.1	157	Тухай жилийн төсөв	92.9	93.7
		Худалдан авал ажиллагааны төлөвлөгөө	88.5	
		Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө	99.4	
6 дугаар зүйлийн 6.1.2		Хагас жилийн төсвийн гүйцэтгэл	96.8	97.0
		Өмнөх оны төсвийн гүйцэтгэл	98.1	
		Сар, улирлын төсвийн гүйцэтгэл	96.2	
6 дугаар зүйлийн 6.1.3		Жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны дотор мэдээлбэл зохин дараа жилийн төсвийн төсөл	96.8	96.8
6 дугаар зүйлийн 6.1.4		Жилийн бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор мэдээлбэл зохих хагас жилийн санхүүгийн тайлан	100.0	99.3
		Дараа жилийн 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор мэдээлбэл жилийн эцсийн санхүүгийн тайлан	98.7	
6 дугаар зүйлийн 6.1.5		Тухайн жилийн 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор бүрэн эхээр нь мэдээлбэл	100.0	85.3



	зохих төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлт		
	Тухайн жилийн 7 дугаар сарын 01-ний өдрийн дотор мэдээлбэл зохио аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	70.7	
6 дугаар зүйлийн 6.1.6	Улирал бүр мэдээлбэл зохио төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	46.8	46.8
Нийт хэрэгжилт		89.0	

Мэдээллийн хувь дутуу байгаад төсвийн байгууллагууд төсвийн хэтрэлт, хэмнэлт түүний шалтгааны тайлбар болон аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг 46,8-70,7 хувьтай мэдээлсэн нь нөлөөлсөн байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх заалтын хэрэгжилт 54.2 хувьтай байна.
Хүснэгтээр харуулбал

Хүснэгт №2

Шилэн дансны тухай хуулийн холбогдох зүйл, заалт	Мэдээлэх мэдээлэл	Хэрэгжилтийн хувь
6 дугаар зүйлийн 6.4.1	тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	97.5
6 дугаар зүйлийн 6.4.2	тухайн байгууллагын төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт	98.7
6 дугаар зүйлийн 6.4.3	тендер, худалдан авалттай холбоотой мэдээлэл	62.4
6 дугаар зүйлийн 6.4.4	таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт	18.9
6 дугаар зүйлийн 6.4.5	цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлага	20.0
	таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого	37.5
6 дугаар зүйлийн 6.4.6	худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнгийн талаар	96.2
6 дугаар зүйлийн 6.4.7	байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт	98.1



6 дугаар зүйлийн 6.4.8	бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	12.3
Нийт хэрэгжилт		54.2

Мэдээллийн хувь хангалтгүй байгаа шалтгаан нь тендер шалгаруулалтын талаарх мэдээлэл, худалдан авалтын тайлан, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл, нэмэлт санхүүжилтийн дансны таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой тушаал, шийдвэрийг бүрэн мэдээлэхгүй байгаатай холбоотой байна. Аймгийн ТЕЗ-ийн төсөвт хамаарах байгууллагуудын хувьд мэдээллүүдийг бүрэн мэдээлэх байдал 71.7 хувь, хугацаа хоцролт 20.0 хувьтай байна.

Улсын төсвийн 43 байгууллагад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг УАГ-аас ирүүлсэн шалгах хуудсаар үнэлэхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Аймгийн Мэргэжлийн хяналтын газар

- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 1 гүйлгээг мэдээлээгүй
- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 9 гүйлгээг мэдээлээгүй
- Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 2 тушаал шийдвэр мэдээлээгүй
- Шилэн дансны цахим хуудсанд 149 мэдээлэл байршуулахаас 22 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2. Боловсрол, соёл, урлагийн газар

- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 7 гүйлгээг мэдээлээгүй
- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 53 гүйлгээг мэдээлээгүй
- Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 3 тушаал шийдвэр мэдээлээгүй
- Шилэн дансны цахим хуудсанд 149 мэдээлэл байршуулахаас 27 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3. Уламжлалт эмнэлэг

- Шилэн дансны цахим хуудсанд нийт 149 мэдээлэл байршуулахаас 52 мэдээлэл оруулаагүй, 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

4. Политехникийн коллеж

- Тендер, худалдан авалттай холбоотой мэдээллээ мэдээлээгүй
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 20 гүйлгээг мэдээлээгүй
- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 17 гүйлгээг мэдээлээгүй
- Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 78 тушаал шийдвэр мэдээлээгүй



- Шилэн дансны цахим хуудсанд 149 мэдээлэл байршуулахаас 17 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.
- 5. *Буйр нуур, мэнэнгийн талын сав газрын захиргаа*
 - Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 2 гүйлгээг мэдээлээгүй
 - Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 5 тушаал шийдвэр мэдээлээгүй
 - Шилэн дансны цахим хуудсанд 149 мэдээлэл байршуулахаас 26 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.
- 6. *Онон, Улз голын сав газрын захиргаа*
 - Дараа жилийн төсвийн төсөл мэдээлээгүй
 - Төсвийн хэтрэлт, хэмнэлт түүний шалтгааны тайлбар бичээгүй
 - Санхүүгийн тайлангаа хагас, бүтэн жилээр байршуулаагүй
 - Шилэн дансны цахим хуудсанд 149 мэдээлэл байршуулахаас 45 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.
- 7. *Эрүүл мэндийн газар*
 - Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнд буруу мэдээлэл байршуулсан
 - Төсвийн хэтрэлт, хэмнэлт түүний шалтгааны тайлбар бичээгүй, бүтэн жилийн мэдээ оруулаагүй
 - Төсөв, мөнгө зарцуулсан 10 тушаал шийдвэрийг байршуулаагүй
 - Нийтийн албан нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл оруулаагүй
 - Шилэн дансны цахим хуудсанд 149 мэдээлэл байршуулахаас 34 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Дорнод аймаг дахь Хилийн цэргийн болон зэвсэгт хүчний ангиуд нь Шилэн дансны цахим хуудсанд Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын батлан хамгаалах салбарын төрийн нууцад хамаарах мэдээллийг байршуулсан байна. Үүнд:

1. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)
2. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)
3. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр)
4. Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан (Бүтэн жилээр)

Энэ нь нууцад хамаарах мэдээллийн жагсаалтын 52-т “Зэвсэг, байлдааны техник, хүн хүчний тоог тодорхойлсон ар тал, санхүүгийн хангалт, төлөвлөгөө, төсөв, тооцоо, мэдээ, шалгалтын акт”, 53-т “Мөнгөн хөрөнгийн нэгдсэн захиалга, санхүүжилт, түүнд холбогдох мэдээ, баримт тооцоо” гэж заасантай нийцэхгүй байна.



1.2 Мэдээллийн самбар дахь шилэн дансны мэдээллийг тухай бүр шинэчлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 5.7.-д “Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг энэ хуулийн 5.1-д заасан цахим хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулна.” гэсэн заалтын хэрэгжилтийг аудитын түүвэрт хамрагдсан Дорнод аймгийн Баянтүмэн, Баян-Уул, Баяндун, Дашбалбар, Цагаан-Овоо, Матад, Хэрлэн, Чойбалсан сумдын төсөвт байгууллагуудын хувьд шалгалаа.

Эдгээр байгууллагуудаас мэдээллийн самбар дахь шилэн дансны мэдээллийг шинэчлээгүй, бүрэн байрлуулаагүй дараах газрууд байна. Үүнд:

- Гэрэл сэтгэмж ОНӨҮГ
- Чойбалсан хөгжил ОНӨҮ
- Чойбалсан сумын төрийн сан
- Чойбалсан сумын сургууль
- Чойбалсан сумын цэцэрлэг

Байгууллагууд нь санхүүгийн мэдээллийн самбарыг олон нийт мэдээлэлтэй чөлөөтэй танилцах боломжтой хэсэгт байрлуулсан байна.

2. ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 3 ДУГААР ЗҮЙЛИЙН 3.1.3, 3.1.4, 3.1.5-Д ЗААСАН БАЙГУУЛЛАГУУД ХУУЛЬД ЗААСАН МЭДЭЭЛЛҮҮДИЙГ БҮРЭН МЭДЭЭЛСЭН БАЙНА.

2.1. ДБЭХС ТӨХК нь Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани гэсэн заалтад хамаарах “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК нь Шилэн дансны тухай хуулийн 6.8 дахь заалтын дагуу шилэн дансны цахим хуудсанд 7 төрлийн мэдээллийг мэдээлэхээр байна.

Хуулийн 6.8.2-т заасан худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг мэдээлсэн, мөн тендер худалдан авалттай холбоотой мэдээлбэл зохих 128 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Хуулийн 6.10 дугаар зүйлд “Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдээгдлийг хавсаргасан байна” гэж заасны дагуу эрх бүхий мэдээлбэл зохиох 81 хүн мэдээллээ бүрэн оруулсан байна.

Хуулийн 3.2.5-д “Засгийн газар, орон нутгийн өрийн бичиг, бусад санхүүгийн хэрэгсэл, шийдвэрийн талаарх мэдээлэл” гэж заасны дагуу нийт 199 тушаал, шийдвэр мэдээлэхээс 195 шийдвэрийг мэдээлж, 4 тушаал, шийдвэр мэдээлээгүй байна.



Хуулийн 3.2.7-д заасан “Төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концессын талаарх мэдээлэл”, 3.2.8-д заасан “Засгийн газрын орон нутгийн баталгаа, Төрийн байгууллага, улсын төсөвтэй холбоотой үүссэн өр, авлагын талаарх мэдээлэл”, 6.8.3-т заасан “Их хэмжээний хэлцэлд тооцогдохуйц баталгаа батлан даалтын шийдвэр”-үүд тайлант хугацаанд гараагүй байна.

2.2 Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр, хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын мэдээлэл аймгийн ЗДТГ шилэн дансны цахим хуудсанд бүрэн мэдээлэгдсэн байна.

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д заалтад хамаарах улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд нь шилэн дансны цахим хуудсанд тусдаа цэс нээлгээгүй байна.

Хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний захиалагч болох аймгийн Засаг даргын тамгын газар нь хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх¹ заалтыг хэрэгжүүлж, улс, орон нутаг болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар олгосон 125 төсөл, арга хэмжээний 11.161,2 сая төгрөгийн санхүүжилт, гүйцэтгэгч аж ахуй нэгжүүдийн талаарх мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд бүрэн мэдээлсэн байна.

2.3 Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллагууд шилэн дансны цахим хуудсанд зарлага, санхүүжилтийн мэдээллээ байршуулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 3.1.5-д заасан “Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллага” болох нийт 14 байгууллага нь шилэн дансанд бүхэн хамрагдсан байна.

Тайлант онд шилэн дансны цахим хуудсаар 11 байгууллага буюу 80 хувь нь төрөөс олгосон санхүүжилтээ мэдээлсэн байна.

“Нархан” цэцэрлэг, “Нарлаг ордон” цэцэрлэг, “Түгээмэл оюу” сургууль санхүүжилтийг мэдээлээгүй байна. Шилэн дансны цахим хуудсанд санхүүжилтээ мэдээлээгүй шалтгаан нь Хэрлэн сумын ЗДТГ-аас улиралд авах санхүүжилт нь 10,0 сая төгрөгт хүрэхгүй байсантай холбоотой байна.

¹ “Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилтээр ... төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг ... санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно. Мэдээллийг төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулахад энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд төлбөр төлөхгүй”



3. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ХАМРАХ ХҮРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫГ ХЯНАЛТ ШАЛГАЛТАД БҮРЭН ХАМРУУЛСАН Ч ХЭРЭГЖИЛТИЙГ БОДИТОЙ ҮНЭЛЭЭГҮЙ БАЙНА.

3.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудыг хяналт шалгалтад бүрэн хамруулж, бодитой үнэлж, дүгнээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ.” гэж заасны дагуу аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас ТЕЗ-ийн хамрах хүрээний 161 байгууллагын шилэн дансны үйл ажиллагаанд улирал бүр дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудас дахь аймгийн ТЕЗ-ийн хүрээний байгууллагуудын мэдээлэлд дүн шинжилгээ хийж, зарим байгууллагыг түүвэрлэн шалгасан байна. Аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 2019 оны 1 дүгээр улиралд 92,0 хувь, 2 дугаар улиралд 93.2 хувь, 3 дугаар улиралд 99.0 хувь, 4 дүгээр улирлын байдлаар 99.9 хувиар дүгнэсэн байна. Аудитын дүнг аймгийн ИТХ, аймаг, сумдын Засаг дарга нарт хүргүүлж ажилласан байна.

Аймгийн Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн хамрах хүрээний орон нутгийн төсөвт 157, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч 14, нийт 171 байгууллага шилэн дансны тухай хуульд хамрагдахаас 161 байгууллагыг хамруулан хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Байгууллагууд нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллээ тогтмол байршуулж хэвшсэн нь Санхүүгийн хяналт, аудитын албанаас жил бүр хийж байгаа хяналтын үр дүнтэй холбоотой ч Төрийн аудитын газраас хийсэн нийцлийн аудитаар 2019 оны шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 71,7 хувьтай байгаа нь дотоод хяналтын ажлын чанар хангалттай хэмжээнд хүрэхгүй байгааг харуулж байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь шилэн дансны цахим хуудсан дахь мэдээллийг хугацаандаа байршуулахад анхаарч ажилласан ч байршуулсан мэдээллийн агуулга хуулийн шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.4 Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2019 онд хийсэн нийцлийн аудитаар аймгийн Засаг даргад “Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны мэдээлэлтэй холбоотой зөрчил арилгуулах тухай” 01/48 тоот, Хэрлэн сумын Засаг даргад “Шилэн дансны тухай хуулийн 3.1.5 дахь заалтад хамаарах байгууллагатай



холбоотой зөрчил арилгуулах тухай” 02/49 тоот, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-д “Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой зөрчил арилгуулах тухай” 1/111 тоот албан шаардлагууд өгснийг 3 байгууллага бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. Албан шаардлагад дурдагдсан зөрчлүүд энэ онд хийгдсэн аудитаар илрээгүй.

Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4-д заасан мэдээллийг бүрэн мэдээлж ажиллах, байгууллагын мэдээллийн самбарт Шилэн дансны тухай хуулийн 5.7 дахь заалтын дагуу бүрэн мэдээлж байх, аудитын дүнг сумдын Засаг дарга, аймгийн харьяа агентлагуудын удирдлагуудад танилцуулж ажиллах гэсэн зөвлөмжүүдийн дагуу аймгийн санхүү, төрийн сангийн хэлтсээс сумдын төсвийн байгууллагуудад мэдээллийн самбарт санхүүгийн мэдээллийг бүрэн байршуулж байх талаар заавар өгч ажилласан байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Аймгийн төсвийн байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4-т заасан мэдээллийг 71,7 хувьтай мэдээлсэн байна.
2. Мэдээллийн самбар дахь шилэн дансны мэдээллийг тухай бүр шинэчлээгүй байна.
3. ДБЭХС ТӨХК нь Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.
4. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр, хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын мэдээлэл аймгийн ЗДТГ шилэн дансны цахим хуудсанд бүрэн мэдээлэгдсэн байна.
5. Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллагууд шилэн дансны цахим хуудсанд зарлага, санхүүжилтийн мэдээллээ байршуулсан байна.
6. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудыг хяналт шалгалтад бүрэн хамруулж, бодитой үнэлж, дүгнээгүй байна

Аудитаар мэдээлбэл зохих мэдээллийг мэдээлээгүй зөрчилд 8 албан шаардлага, дотоод хяналттай холбоотой 3 зөвлөмж өгч, нэгтгэсэн тайланд тусгуулах 1 саналыг хүргүүлээ.



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:

Б.Батмунхуу:
Тайлан үзэж
хэлэлцүүлж
догоо байгуулж
МА он тусламж
баталгаануудыг
ЧЯТ-н хүрээнд
2020.05.06
2020.04.30

МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
21000, Чойбалсан, Дорнод аймэг
Утас: 7058-4202, факс: 7058-4584

№ 7/1081
тантай 2020.04.30-ны № 358 -т

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Б.БОЛОРТУУЛ ТАНАА

Таны энэ өдрийн амгаланг айлтгая.

Үндэсний аудитын газрын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөний дагуу Дорнод аймгийн "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитын тайлантай танилцлаа.

Цаашид өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг ханган ажиллаж, хариуг тогтоосон хугацаанд хүргүүлэх болно.

Хүндэтгэсэн,

ЗАСАГ ДАРГА



М.БАДАМСҮРЭН

010620363



ДЭЭД ШАТНЫ БАЙГУУЛЛАГАД ХҮРГҮҮЛЭХ САНАЛ:

Үндэсний аудитын газарт:

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг шийдвэрлэх талаар холбогдох газарт уламжлах. Үүнд:

1. Хилийн цэргийн болон зэвсэгт хүчний ангиуд нь Шилэн дансны цахим хуудсанд Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын батлан хамгаалах салбарын төрийн нууцад хамаарах мэдээллийг байршуулсан байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дараах албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга М.Бадамсүрэнд:

1. Аймгийн ТЕЗ-ийн нэгдсэн санхүүгийн тайланд нэгтгэгддэг байгууллагуудыг шилэн дансны хяналт шалгалтад бүрэн хамруулах
2. Орон нутгийн төсвийн байгууллагад хийх шилэн дансны дотоод хяналт шалгалтыг чанартай хийж бодитой үнэлж дүгнэж байх.
3. Мэдээллийн самбар дахь шилэн дансны мэдээллийг тухай бүр шинэчилж байх.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2020 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ:



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2020 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 08

Чойбалсан хот

Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/188 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, Нийцлийн аудитын түр журам"-ын 9.2 дахь заалт, Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал бөгөөд Тэргүүлэх аудитор С.Энхбаатар, аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн нарт тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор /Б.Батжаргал/-д даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

110419093



Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын 2020 оны
05 дугаар сарын 07-ны өдрийн
08 дугаар тушаалын хавсралт



Албан шаардлагын жагсаалт

№	Байгууллагын нэр	Нийцлийн аудитын дугаар	Албан шаардлага
1	Аймгийн ЗДТГ	ДОА-2020/01/-НА	01/165
2	Буйр нуур, мэнэнгийн талын сав газрын захиргаа		02/166
3	Боловсрол, соёл, урлагийн газар		03/167
4	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар		04/168
5	Онон, Улз голын сав газрын захиргаа		05/169
6	Политехникийн коллеж		06/170
7	Уламжлалт анагаах ухааны төв		07/171
8	Эрүүл мэндийн газар		08/172



ДОРНОД АЙМАГ, ХЭРЛЭН СУМ, 7-Р БАГ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2 ДУГААР БАЙР, 1,2 ДАВХАРТ
УТАС: +976 7058-4203, 7058-4204, 7058-4207
И-МЭЙЛ: DORNOD@AUDIT.GOV.MN , ВЕБ САЙТ: WWW.AUDIT.MN